



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 65


Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас П.Ганзоригийг чөлөөлсүгэй.
2. Монголын даатгагчдын холбооны ерөнхийлөгч Ж.Бат-Оршихыг Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр томилсугай.
3. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг Ж.Бат-Оршиход үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000069